



НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 4/30

Улаанбаатар хот

Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Журам батлах тухай” 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 395 дугаар тогтоол, Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны 7.1 шаардлага, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “Дүрэм батлах тухай” А/15 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Нийслэлийн Өргөө амаржих газрын дүрэм”-ийн 2.6.3 заалтууд, Эрүүл мэндийн яамны 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 4-1/1504 дугаартай албан бичиг, Удирдлагын багийн 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Амаржих газрын “Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам”-ыг нэгдүгээр, Удирдлагын багийн гишүүд, тасгийн эрхлэгч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар, Эмч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг гуравдугаар, Эх баригч, сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтний ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг дөрөвдүгээр, Эрүүл мэндийн бусад ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тавдугаар, тайлангийн ерөнхий загварыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг эрүүл мэндийн ажилтнуудад танилцуулж, Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудыг идэвхжүүлэх, урамшуулах зорилгоор хариуцсан алба, тасаг ажилтнуудын ажлын үр, дүн гүйцэтгэлийг бодитой үнэлж, дүгнэхийг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /О.Баянжаргал/, Байгууллагын бодлого төлөвлөлт хариуцсан орлогч дарга /Д.Наранцацралт/, албадын дарга тасгийн эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг урамшууллын зардлаас гаргахыг Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч Ч.Гангэрэлд зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Дотоод хяналт шалгалт эрхэлсэн ажилтан /Ц.Мөнхцэцэг/-т даалгасугай.

5. Тушаал гарсантай холбогдуулан Даргын 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/27 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  А.ДҮҮРЭНБИЛЭГ



1119287569 9077006